



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 4/61

Улаанбаатар хот

Г

Г

Тоног төхөөрөмжийн жагсаалт,
техникийн үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XV.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн XV.3.3-т заасан “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний тоо хэмжээ, техникийн үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилтийн биелэлтийг ханггуулж ажиллахыг Санхүү эдийн засгийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс /Т.Хонгорзул/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.


С.ЧИНЗОРИГ

141223286

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
02 дугаар сарын 15-ны өдрийн
4/61 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /УЛСЫН ХЭМЖЭЭНД/ ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСАЛТ

№	ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭР	ТОО ХЭМЖЭЭ	НЭГЖ ҮНЭ /ТӨГРӨГ/	НИЙТ ҮНЭ /ТӨГРӨГ/	САНХҮҮЖИ ЛТИЙН ЭХ ҮҮСВЭР
1	Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар тойргийн 1, 2, 3, 4, 5, 6, 20, 22, 24, 26, 32, 33, 34, 35, 36, 37, 41 хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүд	Автомашин	18	38,000,000	684,000,000	
2		Мобайл тоног төхөөрөмжийн иж бүрдэл	18	17,000,000	306,000,000	
3	Баянзүрх дүүрэгийн 50 ортой эмнэлэг /21-р хороо Дарь эх/, Амгалан амаржих газар, Энэрэл эмнэлэг, Өвөрхангай аимгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв Төв аймаг Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв, Сүх баатар аймаг Асгат сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар аймаг Мөнххаан сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар сумын Дарьганга сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв	Хүчилтөрөгчийн аппарат	9	112,222,220	1,009,999,980	2023 оны Улсын төсөв XV.3.3
	НИЙТ		45		1,999,999,980	

Автомашин:

- Марк: TOYOTA Prius 41 эсхүл түүнтэй дүйцэхүйц байх

- Мотор: 1800-сс багагүй байх
- Шатахуун: Бензин
- Суудлын тоо /хүн/: 5
- Шатахуун зарцуулалт /литр/-6-10л
- Үйлдвэрлэсэн он: 2012 ба түүнээс хойш
- Хурдны хайрцаг: Автомат
- Дугуй: Өвөл 4 ширхэг, Зуны 4 ширхэг Нийт 8 дугуйтай байх
- Өнгө: Цагаан, Усан цэнхэр, Саарал
- Км гүйлт: 100,000 км-ээс ихгүй байх
- Монголд 2023 онд орж ирсэн Улсын дугааргүй байх
- Дагалдах иж бүрдэл: Запас дугуй 1ш, домкрат, дугуйн түлхүүр
- Тос, масло сольсон, авто техникийн улсын үзлэгт оруулсан

Мобайл тоног төхөөрөмжийн иж бүрдэл:

Иж бүрдэлд дагалдах зүйлс:

- Таблет: 1 ширхэг
- Зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат (ЭКГ): 1 ширхэг
- Зөөврийн ЭХО аппарат: 1 ширхэг
- Дааралтын аппарат: 1 ширхэг
- Холестрин хэмжигч: 1 ширхэг
- Сахар хэмжигч: 1 ширхэг
- Пульсокиметр: 1 ширхэг

Таблет:

- 9"-ээс багагүй TFT LCD дэлгэцтэй байх
- Мобайл технологийн тоног төхөөрөмжтэй холбогдож ажиллах боломжтой байх
- WiFi, bluetooth дэмждэг байх
- WiFi ашиглан оношилгооны тоног төхөөрөмжтэй холбогдон интернэтгүй орчинд оношилгоо хийх, зураг, бичлэг хадгалах боломжтой байх
- Үйлдлийн систем: Apple iOS ба Android

Зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат (ЭКГ)

- Зүрхний цохилт болон импульсийн хэмжээ, тосгуурын фибрилляци, зүрхний түр зогсолт зэргийг хянадаг байх
- Нэг болон хоёр хэрэглэгчийн горимтой байх
- Тогтмол бус зүрхний цохилтын анализ хийдэг байх
- Android болон iOS үйлдлийн системд зориулагдсан програмтай байх
- Pdf хэлбэрээр компьютерт тайлан илгээх, хэвлэх боломжтой байх
- Дэлгэц: 2.4 инч ба түүнээс дээш өнгөт LCD дэлгэцтэй байх
- Зүрхний цохилтын давтамж: 30-250 bpm

Зөөврийн ЭХО аппарат 2 талдаа датчиктай

- Таблеттай холбогдож, хэт авиан оношилгоо хийх боломжтой байх
- Горим: В, В/M, өнгөт допплер хувилбар В + Өнгө, В + PDI, В + PW
- Датчикийн төрөл: Convex, phased+linear array байх
- Цэнэглэдэг баттарейтай байх
- Утасгүй цэнэглэх боломжтой байх

Даралтын аппарат

- iOS болон Android үйлдлийн системд холбогдох боломжтой байх
- Цэнэглэдэг баттарейтай байх
- Өөр дээрээ OLED дэлгэцтэй байх
- Олон хэрэглэгчийн горимтой байх
- АНА гипертензийн үнэлгээ хийгддэг байх
- Ханцуйны диаметр: 22-42 см байх
- Bluetooth 4.0 дэмждэг байх

- Цусны даралт хэмжих хязгаар: 1-300 mm Hg
- Хэмжих аргачлал: Осциллометр
- Манжатакны даралтын хязгаар : 0-295 mm Hg
- Хэмжилтийн алдаа: ± 3 mm Hg
- Пульс хэмжээ: 40-200 минутанд цохилох тоо

Холестрин хэмжигч

- Мэдрэгч: Электрохимийн биосенсор
- Хэмжилтийн хугацаа: 30 секундээс ихгүй
- Дээжийн эзлэхүүн: 2.5-10,3 ммоль/л
- Сорьцын хэмжээ: 20мкл-с доошгүй
- Сорьцын төрөл: Бүхэл цус, ийлдэс, сийвэнд шинжилгээ хийгддэг байх
- Санах ой: 500-аас багагүй хэмжилт хадгалдаг байх
- 25-аас багагүй тест дагалдуулж өгөх

Сахар хэмжигч

- Дээжийн эзлэхүүн: 0.7-1,0мкл
- Хэмжилтийн хугацаа: 10 секундээс ихгүй
- Санах ойн хэмжээ: 300 -аас багагүй хэмжилт хадгалдаг байх
- Хэмжих хязгаар: 1,1-33,3ммоль/л
- Цахилгаан тэжээл: Цэнэглэдэг батарейтай байх
- 50-аас багагүй тест дагалдуулж өгөх

Пульсоксиметр

- Төрөл: Хурууны байх
- Фотоплетизографийн технологоор хэмжилт хийдэг байх
- OLED дэлгэцтэй байх
- Хэмжилтийн нарийвчлал: 80-100%
- Зүрхний цохилт хэмжих хязгаар: 30bpm-240bpm
- SpO₂ хэмжих хязгаар: 35-100%

ХҮЧИЛТӨРӨГЧИЙН АППАРАТ /NF MOSS-450 BS, NF MOSS-300 BS, NF MOSS-150 BS дүйцэхүйц/:

- Технологи: PSA
- Урсгалын хурд Flow Rate(LPM)/(Nm³/hr): 45LPM+-10%
- Хүчилтөрөгчийн цэвэршилт: 93+-3%
- Даралт: 4.0 ± 0.5 bar
- Зориулалт: Эмнэлгийн зориулалттай хүчилтөрөгч
- Стандарт: ISO олон улын стандартыг хангасан байх
- Ажиллах горим: Бүрэн автомат
- Тэжээлийн хүчдэл: Хувьсах хүчдэлийн 220В 50/60 Гц 1.8 KW/h ба түүнээс дээш